

ХОРТ ХАВДРААР ОНОШЛОГДСОН ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЦЭЭГ  
МОНГОЛД НЭМЭГДҮҮЛЭХ  
/АНУ-ЫН АЛЯСКА МУЖИЙН ТУРШЛАГА/

**А. Батхишиг**

МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн дэд профессор  
Orchid ID: 0000-0001-8416-3744

**С. Нарантуяа**

МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн дэд профессор  
Orchid ID: 0000-0003-1736-4313

**Г. Түмэнхишиг**

МУИС-ийн Социологийн хөтөлбөрийн магистрант  
Orchid ID: 0009-0007-8512-801X

**Abstract:** *It is important to raise awareness of the increasing number of cancer patients worldwide. Also, people should be knowledgeable enough to know that the early detection of cancer can be treated fully. Scientists around the world have been studying cancer causes and providing many solutions and treatment methods to overcome cancer. One of the inseparable causes of cancer in human life is food and culture. Therefore, countries are required to develop compatible cancer support programs for patients. The goal of this article is to study more about the cancer support programs for nomadic Mongolians and increase the number of programs. The examples of the American Cancer Society of Alaska Anchorage, the location and lifestyle which shares similarities to the nomadic Mongolian lifestyle.*

**Key words:** *Culture and cancer, history of cancer, compatible cancer support program, programs for nomadic.*

**ОРШИЛ:**

Анагаахын шинжлэх ухааны үсрэнгүй хөгжлийн эрин үед хорт хавдар хэмээх өвчнийг бүрэн оношилж, учир шалтгааныг нь одоо хүртэл тогтоож чадаагүй байна. Хорт хавдрын эмчилгээнд зонхилох байрыг эрт илрүүлэг хэмээх ойлголт онцгой нөлөөтэй байна. Магадгүй хорт хавдар нь 3-4 дүгээр үедээ шатандаа орсон бол аль ч улс оронд эмчлэгдэх магадлал бага байгаа нь зөвхөн Монголын статистик баримт бичиг харуулж байгаа биш, дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын статистик үзүүлэлт ч мөн харуулж байна. Буурай хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад манай орон хамрагдаж байгаа нь энэхүү өвчний түүх болоод өвчлөгсдийн өмнө нийгэм манай улс ямар хариуцлага хүлээх, өвчнийг хөнгөвчлөхөд нийгмийн сэтгэл зүй ямар төвшинд байгааг өндөр хөгжилтэй орны бэлээхэн туршлагатай харьцуулахад хангалттай биш байна гэж үзэж байна. Шинжлэх ухааны ололт гэхээсээ илүү хүн амын нийгмийн хандлагад дорвитой өөрчлөлт гаргах нь манай улсын хувьд үр өгөөжтэй байна. Бид өнөөдөр бусад орны адил хүн амынхаа ахуй амьдралд нийцсэн үйлчилгээг үзүүлэх нь өнөөгийн нийгэмд хэрэгтэй байна.

**ХОРТ ХАВДРЫН ТҮҮХЭЭС:**

Хорт хавдар гэдэг өвчин нь шинэ зүйл огт биш юм. Хүн төрөлхтний түүхэнд хүн, амьтны биед ажиглагдсаар ирсэн гэдгийг Америкийн Хорт Хавдартай Тэмцэх Нийгэмлэг /American Cancer Society /- ийн цахим хуудас дахь “Хорт хавдрыг ойлгох нь: Эртний үе ба өнөө үе” гэдэг сэдэвтэй өгүүлэлд бичжээ. Манай Эриний Өмнөх /МЭӨ/ 3000-аад жилийн өмнө Египет улсын нэгэн номд хорт хавдрыг “Эдвин Смитийн Папирус” гэж нэрлэсэн байжээ. Эртний Египетийн мумми буюу

занданшуулсан шарилд шинжилгээ хийхэд ясны хорт хавдрын өсөлтийг олж таньсан байна. Үүнийгээ остеосаркома /Osteosarcoma/ гэж нэрлэсэн байжээ. Өөр нэг баримт дурдахад, Грекийн эмч “Анагаах ухааны эцэг” гэгддэг Гиппогат /Hippocrates/ шархлаа үүсгэдэггүй хавдрыг Карцино /Carcinos & Carcinoma/ буюу энэ нь эртний Грек хэлээр **ХАВЧ** гэсэн үг бөгөөд энэ өвчний хэлбэр нь хавчийг санагдуулам хэлбэр дүртэй байдаг гэх мэт хорт хавдрын талаарх маш олон нэршил байгаа нь хорт хавдрыг хүн төрөлхтний түүхэнд байсаар ирсэн өвчин гэдгийг баталж байгаагийн зэрэгцээ өнөөгийн төвшинд хүртэл олон эрдэмтэд олон жилийн турш судалгаа, шинжилгээ хийж ирсэн байна. Хавч гэдэн үг нь орчин цагийн англи хэлний Cancer /Кансэр/ гэдэг үг бөгөөд Монголчууд бид хортой хавдар гэж нэрлээд аль хэдийнээ дадсан байна.

15-р зууны эхэн үе буюу сэргэн мандалтын үед эрдэмтэд хүний биед илүү шинжлэх ухаалаг арга ашиглан судалгаа шинжилгээ хийж эхэлсэн нь хорт хавдар гэгдэх өвчин дэлхий нийтийн асуудал болсон байна. Бид хүний бие дэх хавдрыг хортой болон хоргүйг нь ялгадаг болсон байна. Хортой хавдар нь I-IV үе шаттай байдгийг тодорхойлоод зогсохгүй хүний биеийн аль ч хэсэгт үүсэж болдог учир биеийн аль хэсэгт үүссэнээс шалтгаалан нэршил бүр нь өөр байдгийг өнөөгийн эрдэмтэд тогтоож чаддаг болтлоо хорт хавдрын судалгааг хөгжүүлж ирсэн байна. Ямар хавдар хэд дүгээр үе шатандаа зөвхөн хагалгаа хийхэд эдгэрдэг, алийг нь хорт хавдрын сүүлийн шат буюу эмчлэгдэх магадлал багассан үе шат гэдгийг хүртэл тодорхойлчихдог болсон байна. Үүний зэрэгцээ дэлхийн улс орнууд хавдраар оношлогдсон хүний биеийн болон ахуй амьдрал, зан үйлийн онцлогт нийцүүлэн төрөл бүрийн хөтөлбөрүүдийг өвчтөний бие сэтгэл зүй болоод амьдралыг чанарыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлдэг байна.

Хорт хавдрын гарал үүслийн талаар олон үзэл бодол байдгаас хамгийн сонирхолтой нь эртний Египтчүүд хүний биед хорт хавдар үүссэн шалтгаанд бурхныг буруутгаж зүхдэг бол Гиппогратын үе (МЭӨ 370 он)-д өөрөөр авч үздэг байсан нь уншиж судалсан ном, өгүүллээс ойлгогдож байна. Гиппогратын үед шашны шалтгаанаар хүний биед задлан шинжилгээ хийхийг хориглодог байсан үе тул хүний бие 4 төрлийн шингэнээс бүтдэг: цус, цэр, шар цөс болон хар цөс гэсэн 4 төрлийн шингэний бүрдэл учир энэ 4 шингэний тэнцвэр хэт ихсэх эсвэл хэт алдагдах юм бол хүний биед өвчлөл үүсдэг гэж Гиппогат үзжээ. Үүнийгээ Humoral Theory буюу “Хүний Биеийн Шингэний Онол” гэж нэрлэсэн байна. Түүний үзэл баримтлалаар хүний амьдрах орчин болон идэх уух зүйлс хүний биеийн хар, шар шингэнийг тэнцвэржүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үздэг бол энэхүү үзэл нь дундад зууны үед Ромчуудад өвлөгдөн тэр үеийн анагаах ухааны нэрт зүтгэлтэнд Галены үзэл баримтлал болон дамжин явсаар дундад зууны үеийн анагаах ухааны стандарт болтлоо хөгжиж байсан нь анагаах ухааны түүхэн баримтуудад тусгагдсан байна. Гиппогратын энэхүү онол үзэл баримтлал нь 1300-аад жил оршин тогтноод 1850-аад онд **Germ Theory буюу Үр Хөврөлийн Онолоор** үгүйсгэгдсэн хэдий ч өнөөдрийн эрдэмтдийн үзэл баримтлалд хувьсан үргэлжилсээр хүний биеийн бүтэц нь ус, агаар, гал, газар шороо юм гэсэн үзэл болтлоо хувьсан өөрчлөгдөж хожим хүний сэтгэл зүй, зан төлөвтэй ч холбон тайлбарлаж байсан байна. Ингэхдээ хүн 4 төрлийн темпераменттай буюу зан төлөвтэй /сангвиник, холерик, меланхолик, флегматик/ эдгээр нь хүний өөрийн амьдралын хэв магт нөлөөлж хүний эрүүл мэнд, сэтгэл зүй хийгээд амьдралын чанарт нөлөөлж болно гэж үзсэн байна.

#### **ХОРТ ХАВДРЫН ТАЛААРХ СҮҮЛИЙН ҮЕИЙН ЗАРИМ ТОО БАРИМТУУД:**

**Өнөөдөр эрдэмтэд хорт хавдрыг тодорхойлохдоо ... “Хорт хавдар нь хүний биеийн аль нэг хэсэгт эсийн хяналтгүй өсөлт бий болж биеийн хэвийн эд эсийг устган гаж эсүүдийн хэт бөөгнөрөл**

үүссэнээс шалгаалж хүний эрхтэн тогтолцооны аль нэг хэсэгт хорт хавдрын өвчлөл үүсдэг байна” гэж ДЭМБ-аас тодорхойлжээ.

Хорт хавдар хэмээх энэ аймшигт өчний тохиолдлыг ДЭМБ-ын статистик мэдээллээс үзвэл дэлхийн нийт улс оронд жилд 19.2 сая хүн хорт хавдраар өвчилж, 9.9 сая хүн хорт хавдрын улмаас нас барсан статистик байна. Үүнээс манай Монгол улс хорт хавдрын шалтгаант нас баралтын тоогоор дэлхийд нэгд эрэмбэлэгдэж байгаа бөгөөд жил бүр 5000 гаруй хүн хорт хавдраар оношлогдож, 3000 гаруй нь нас барсан харамсалтай тоо баримт олон нийтийн мэдээ мэдээлэлд дурдагдсан байна.

Манай оронд хорт хавдраар өвчлөгсдийн тоо жил тутамд нэмэгдэж 5000-6000 тохиолдол шинээр бүртгэгдэж 2040 он гэхэд нийт 11,647 хүн болж нэмэгдэх төлөвтэй байгаа гэсэн прогноз судалгаа ч гарчээ. Тиймээс бид энэхүү төсөөлхийн аргагүй хүнд нөхцөл байдлыг зүгээр орхих биш доривтой системтэй, үе шаттай хөтөлбөр хэрэгжүүлж урьдчилан сэргийлэхэд анхаарах шаардлагатай болоод байгааг судалгааны баримтууд тодохой илтгэж байна.

Монгол улсад нийт хорт хавдраар оношлогдсон иргэдийн 72,4% нь III-IV үе шатандаа буюу эмчлэгдэх магадлал багассан хожуу үе шаттанд оношлогдож байгаа нь харамсалтай байна. Эрт илрүүлэг, оношлогоонд хамрагдаж хавдрыг эрт үед илрүүлбэл хугацаа алдалгүй эмчлэх бүрэн боломжтой хэмээн эмч мэргэжилтнүүд үздэг. Манай улсад хэрэгжиж байгаа "Эрүүл Монгол Хөдөлгөөн" нь иргэдийг эрт илрүүлгийн шинжилгээнд хамрагдаж ямарваа нэгэн аюулт эдгэрэшгүй өвчтөөс урьдчилан сэргийлэх нэг чухал арга мөн бөгөөд хорт хавдрын өвчлөлийн тохиолдлыг багасгахад ихээхэн нөлөө үзүүлнэ хэмээн үзэж байгаа ч бид нэгэнт хорт хавдраар оношлогсон иргэдэд бусад орны адил системтэй, хүн төвтэй, Монгол улсын иргэдийн ахуй амьдрал зан үйлд нийцсэн цогц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж нэмэгдүүлэх нь чухал байна.

Монголын хорт хавдрын өнөөгийн нөхцөл байдлын талаарх судалгааны статистик мэдээ мэдээллээс харахад, Монгол улсын нийт хорт хавдраар оношлогдсон иргэдийн дунд элэгний хорт хавдраар оношлогдсон иргэдийн тоо бусад төрлийн хорт хавдраар оношлогдсон иргэдийнхээс өндөр хувийг эзэлж байна. Элэгний хорт хавдраас шалтгаалсан нас баралт ч мөн адил бусад төрлийн хорт хавдраар оношлогдсон иргэдээс хамгийн өндөр нь байна. Үүний дараагаар ходоод, уушиг, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэс, умайн хүзүүний хорт хавдрууд зонхилдог байна. Монгол улсын хүн амын дунд 2021 онд 5981 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдсэний 32% нь элэгний хорт хавдар, ходоодны хорт хавдар 16%, уушиг гуурсан хоолой хорт хавдар 7.5%, улаан хоолой 5.6%, умайн хүзүүний хорт хавдар 5.2% эзэлж байгаа бөгөөд энэ төрлийн хорт хавдар нь нас баралтын гол шалтгаан болоод байгаа юм байна.

Хорт хавдрын өвчлөлийн талаар судалж үзэхэд манай орны хүүхдүүдийн дунд ч мөн хорт хавдрын тохиолдууд бүртгэгдсээр байгаа бөгөөд Монгол улсад 2021 оны жилийн эцэст хорт хавдрын өвчлөлийн 456 (нийт хяналтын 1.8 хувь) 0-18 насны хүүхэд байна гэсэн тоо баримт гарчээ. Энэ статистик судалгаанаас харахад хорт хавдрын өвчлөл, нас баралт монгол улсад өдрөөс өдөрт хурдтай өсөн нэмэгдэх хандлагатай байна.

**"ХОРТ ХАВДРААР ОНОШЛОГДСОН ИРГЭДИЙН ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР"-ИЙГ НУТАГШУУЛАХ НЬ:**

Монгол орны цаг уурын онцлог, ахуй амьдралын хэм маяг нийцүүлэн "Хорт хавдраар оношлогдсон иргэдийн дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх нь чухал гэсэн санааг дэвшүүлж байна. Бид эхний ээлжинд хорт хавдрын талаарх дэлгэрэнгүй үнэн зөв мэдээллийг иргэдэд таниулж энэ өвчний эмчилгээ оношилгоог нийгэмд таниулах нь чухал юм. Үүний зэрэгцээ оношлогдсон

иргэдэд "хорт хавдраар оношлогдсон иргэдийн дэмжих хөтөлбөр" - ийг шат дараатай, Монгол орны бүсийн уур амьсгал, хүмүүсийн ахуй амьдралын онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх нь чухал хэмээн үзэж байна.

АНУ-ын Аляска мужийн Энкорэйж хотын их сургууль дахь Нийгмийн Ажлын сургуульд 2009 – 2013 онуудад Нийгмийн ажлын бакалаврын чиглэлээр суралцах хугацаандаа Аляска мужийн хорт хавдартай тэмцэх нийгэмлэг (American Cancer Society of Anchorage Alaska) –д дадлага хийж хорт хавдрын болон хорт хавдраар оношлогдсон иргэдэд чиглэсэн хөтөлбөрийн талаар төгсөх жилдээ нилээдгүй хэмжээний туршлага судалсан юм. Аляска мужийн хамгийн том хот болох Энкорэйж нь нийт 800 орчим мянган хүн агтай муждаа хамгийн их хүн амтайд хотод тооцогддог /нийт хүн амын тал нь/ бөгөөд төв хот болох Жуно болон хойд хэсэгт байрлах Фэйрбайнкс хотоосоо илүү хүн амын нягтаршил ихтэй хот юм. Энкорэйж хотод Аляска мужийн засаг захиргаа, томоохон эрүүл мэндийн байгууллага зэрэг төрийн захиргааны байгууллагууд болон АНУ-ын томоохон цэргийн бааз байршдаг учир ерөнхийдөө Улаанбаатар хоттой төстэй. Тус муж нь уугуул иргэдийн алслагдсан тосгонуудтай, зөвхөн агаарын тээвэр явах боломжтой алслагдсан тосгон байдаг гэх мэт олон ижил төстэй Монголтой харьцуулан харахад ижил төстэй зүйл ихтэй АНУ-ын хамгийн том газар нутагтай муж юм. Аляска мужийн уугуул иргэд болох Эскимо, Алеут, Юүпик гэх мэт 20 гаруй уугуул үндэстэн ястны хот. Тэдгээр хүмүүсийн амьдралын хэв маяг, тухайн мужийн бүтэц зохион байгуулалт нь Монгол улсынхтай төстэй байсан нь сурах зүйл ихтэй, Монголын алслагдсан сум, аймгийн эрүүл мэндийн үйлчилгээг Аляскагийн тосгоны эрүүл мэндийн үйлчилгээтэй харьцуулан харах боломж олдсон юм.

АНУ-д нэгт бичигддэг, цэвэр өөрийн хандивын сангаараа үйл ажиллагаагаа явуулдаг 100 жилийн түүхтэй төрийн бус байгууллага болох АНУ-ийн Хорт Хавдартай Тэмцэх Нийгэмлэг нь хорт хавдартай олон жил тэмцэж ирсэн, дэлхийд хамгийн олон эрдэмтэн судлаачтай тэргүүлэх байгууллага юм. АНУ-ын ХХТН ТББ нь үндсэн нэг цахим хуудаст хорт хавдрын талаарх мэдээ мэдээллийг байршуулахаас гадна нийт 20 орчим төсөл хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээ мэдээллээ байршуулсан нь ерөнхий үйл ажиллагааны чиглэлүүдийг дэлгэрэнгүй харахад нээлттэй байдаг. Энэхүү цахим хуудас нь хүн бүхэнд нээлттэй нийт 13 хэлээр өөрийн үйл ажиллагаа болох хорт хавдрын талаарх мэдээ мэдээлэл, төсөл хөтөлбөр, судалгаа шинжилгээнийхээ тайлан мэдээллийг түгээдэг учир их өргөн хэрэглээтэй мэдээллийн сантай байгаа нь өнөөгийн цахимжсан нийгэмд амьдарч байгаа иргэдэд хэрэгцээтэй цаг хэмнэсэн үр дүнтэй, үнэн зөв мэдээллийг нэг дороос авахад тустай байдаг.

Аляска мужийн Энкорэйж хот дахь ХХТН нь муждаа үйлчилгээний цар хүрээгээрээ хамгийн томд тооцогддог мужийнхаа дийлэнх хорт хавдраар оношлогдсон иргэдэд анхаарлаа хандуулдаг байгууллага. Тус хот дахь Хорт Хавдрын Зөвлөл (Cancer Council of Alaska), эрүүл мэндийн төвүүд /Providence Health Center, Alaska Reginal Hospital, Alaska Native Medical Center) болон нутгийн уугуул иргэдэд үйлчилдэг Эрүүл Мэндийн Концертиум буюу (Alaska Native Tribal Health Concertium) гэх мэт байгууллагууд нь ХХТН -гэй хоорондын нягт уялдаа холбоотой ажилладаг. Хэдийгээр яс үндэс, шашин шүтлэг гарал үүсэл хамаарахгүй үйлчилгээ үзүүлдэг ч Аляска мужийнхаа бодлогод нийцүүлэн хорт хавдраар оношлогдсон алслагдсан тосгоны иргэдэд тусгай хөтөлбөрийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг. Зарим нэг хөтөлбөрөөс дурдвал: Аляскагийн алслагдсан тосгоны уугуул иргэд эмнэлгийг үйлчилгээ авах бүрэн боломжийг хангах үүднээс уугуул иргэдэд чиглэсэн олон үнэ төлбөргүй үйлчилгээ байдгаас гадна, хагалгааны дараах эмчилгээ үйлчилгээгээр дээрх бүх эрүүл мэндийн төвүүд бүрэн үйлчилдэг. Жишээ нь Alaska Native Medical Center буюу Аляскагийн Уугуул Иргэдийн Эрүүл Мэндийн төв нь алслагдсан тосгоны уугуул иргэдэд зориулан

эмнэлэгт ирэхэд онгоцны буудлаас тосох үйлчилгээ, эмчилгээний явцад эмнэлэг хооронд тээвэрлэх үйлчилгээ болон эмчилгээнд байх хугацаанд түр байрлах боломжтой Quayana House /Куяана хаус/ - аар хангах үйлчилгээнүүдийг зөвхөн алслагдсан тосгоны уугуул иргэдэд зориулсан үйлчилгээнүүдтэй байдаг. Энэ байранд байршиж байгаа уугуул иргэдэд зориулж дотор тохижилтыг Иглүү /Igloo – Аляскийн уугуул иргэдийн уламжлалт сууц/ хэлбэрээр тохижуулсан байдаг. Мөн энэ байранд түр байрлаж байгаа өвчтөн болон тэдний асран хамгаалагч нарт зориулан хандгайн махаар уламжлалт шөл, хоол болон халим загасны хатаасан махаар үйлчилж тухайн өвчтөний бие, сэтгэлийн тав тухыг хангаж өгч байсан нь маш их таалагдсан.

#### **ДҮГНЭЛТ:**

Манай оронд хорт хавдраар өвчлөгсдийн тоо жил ирэх тусам ихсэж байгаа нь тул Хорт хавдраас сэргийлэх, хянах ажлыг эрчимжүүлэх, оновчтой болгож баримт нотолгоонд тулгуурласан бодлого, хөтөлбөр боловсруулах, иргэд болон тэдний ар гэр, асран хамгаалагчдад үзүүлэх үйлчилгээний төрлүүдийг нэмэгдүүлэх мөн тэдгээрийн чанарыг сайжруулах тал дээр анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай байна.

Одоогоор Хавдар Судлалын Үндэсний Төвд үзүүлж байгаа үйлчилгээнүүд нь ерөнхий эм, эмнэлгийн үйлчилгээнээс (үзлэг, оношилгоо, шинжилгээ, мэс засал, туяа, хими, гормон эмчилгээ) сэтгэлзүй, хоол зүй, нийгмийн тусламж, сэргээн засах зэрэг дэмжих үйлчилгээ багтдаг тухай Эрүүл Мэндийн Сайдын 2014 оны 12 сарын 02-ны өдрийн 412 тугаар тогтоолоор баталсан байдаг юм байна.

Гэвч энэхүү дэмжих хөтөлбөрүүд нь эмнэлгийн мэргэжилтэн хийгээд эмнэлгийн багтаамжийн асуудлуудаас шалтгаалан бүрэн хэмжээнд хүрч үйлчилж чадахгүй тун хангалтгүй байгаа юм. Цаашлаад бид хөдөө орон нутгийн иргэдэд Аляска мужид хэрэгжүүлдэг эрүүл мэндийг үйлчилгээг ч үзүүлэх шаардлагатай гэж харж байна.

#### **НОМ ЗҮЙ**

*Монгол хэл дээр*

Б.Одончимэг, (2022). “Хорт хавдрын өвчлөл өнөөгийн байдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл сонсов”, цахим мэдээний хуудас <https://vip76.mn/content/83591>

Т. Ундармаа, (2022). “Хорт хавдрын эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлэх нь” илтгэл.

Ц.Уранчимэг, Л.Энхээ, (2023). “Олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны тайлан”

Хавдар судлалын Үндэсний Төвийн цахим хуудас <https://www.cancer-center.gov.mn/>

Н.Эрдэнэхүү, Г.Оюунжаргал, Г.Хандсүрэн, (2022). “Хорт Хавдрын Тусламж Үйлчилгээний Чанар Хүртээмжийг Сайжруулах нь” илтгэл.

*Англи хэл дээр*

American Cancer Society (2024)., “Understanding What Cancer is: Ancient times to Present”

<https://www.cancer.org/cancer/understanding-cancer/history-of-cancer/what-is-cancer.html>

World Health Organization (2024)., “Prevalence of Cancer” <https://www.who.int/>

Harvard University – Harvard Library., “Historical Views of disease and Epidemics”, Humoral Theory <https://curiosity.lib.harvard.edu/contagion/feature/humoral-theory>